**МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ**

# Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал
## Ерөнхий шаардлага

**MNS 6782:2019**

СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛ ЗҮЙН
СТАНДАРТЫН
БОЛОВСРУУЛАГЧИД
ОЛГОСОН ХУВЬ

Албан хэвлэл

**СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР**

**УЛААНБААТАР ХОТ**

**2019 ОН**

### 5.5 Аж ахуйн зориулалтын бүс

5.5.1 Аж ахуйн бүсэд зоорь, худаг, уурын зуух, агуулах, под станц, гарааш, авто зогсоолтой тохиолдолд тухайн бүсэд нэвтрэхийг хориглосон болон аюултай болохыг анхааруулсан тэмдэг тэмдэглээтэй, хүүхэд авирах, шургах боломжгүй байна.

5.5.2 Уурын зуухны үнс зайлуулалт нь сургуулийн барилгаас тусгаарлагдсан, орчныг бохирдуулахгүй хаалт хамгаалалттай байна.

### 5.6 Хог, хаягдлын цэг

5.6.1 Сургуулийн хог, хаягдал түр хадгалах цэг нь хана, хашаагаар тусгаарласан хаалттай, битүүмжлэл сайтай, хог ангилж хийх боломжтой, сургуулийн барилга байгууламжаас 30 м-ээс, усны эх үүсвэрээс 100 м-ээс багагүй зайд, зонхилох салхины доод зүгт байрлана.

5.6.2 Задгай талбайн хогийн сав нь хогийг ангилж хийх зориулалт бүхий тэмдэг тэмдэглэгээтэй, тагтай байна.

### 5.7 Хяналтын камер

5.7.1 Сургуулийн гадна орчныг бүхэлд нь хянах боломжтой MNS 6423 стандартын шаардлага хангасан хяналтын камер байршуулсан байна. Хяналтын камер нь дараах шаардлагыг хангана:

- Харанхуй, үзэгдэх орчин хязгаарлагдсан үед бичлэг хийх чадвартай;
- хүний зүс царай, гадаад дүр төрх, содон шинж тэмдгийг татаж томруулах боломжтой байх;
- 8 баллын газар хөдлөлт, ±40$^{o}$С-д тэсвэртэй.

5.7.2 Мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангана.

5.7.3 Дүрс бичлэгийг 1 сараас доошгүй хугацаанд хадгалж архивлана.

## 6 Сургуулийн дотоод орчинд тавих аюулгүй байдлын шаардлага

### 6.1 Барилгын аюулгүй байдал

6.1.1 Сургуулийн барилга байгууламжийн аюулгүйн гарц нь аюулт үзэгдлийн үед ашиглахад бэлэн байна.

6.1.2 Аюул, аваар осол гарсан үед барилгаас гарах урсгал хөдөлгөөнийг харуулсан зураг, схем, ааварын гэрэл, дохио тэмдэглэгээг гарц бүрт байршуулна.

6.1.3 Гарцын тэмдэглэгээ харанхуйд гэрэлтүүлнэ.

6.1.4 Барилга байгууламжийн галын аюулгүй байдлын норм ба дүрэм БНбД 21-02-01-д заасны дагуу галын болон аюулгүй байдлын дохиоллын системтэй байна.

6.1.5 Галын аюулын үед ашиглах гидрокрант, галын хор, бусад хэрэгсэлтэй, хэрэглэх зааватай байна.

6.1.6 Сургууль цахилгаан шат /лифт/-тай бол бүхээгийн гадна, дотор байрлах товчлуур болон ааварын хонх нь хүүхэд, тэргэнцэртэй иргэн хүрэх түвшинд хаалганы 2 талд байрлана.

6.1.7 Цахилгаан шат нь давхар тус бүрийг мэдээллэх дуут дохио болон тоон тэмдэглэгээтэй байна.

6.1.8 Цахилгаан шат нь тэргэнцэртэй иргэн нэвтрэх боломжтой байна.

6.1.9 Цахилгаан шат нь байнгын гэрэлтүүлэг, аюулгүй ажиллагааны зааварчилгаатай байна.

6.1.10 Хүүхэд унаж бэртэхээс сэргийлж цонхны салхивчны онгойх өнцгийг хязгаарласан түгжээтэй, хэрэв цонхны тавцан шалнаас 1 м-ийн өндөрт байрлах тохиолдолд хамгаалалтын хаалттай байна.

## Гадна камер суурилуулах схем /ЕБС/

/8ш камер/




2020.03.20






Камерын байршил

**1-р давхарт камер суурилуулах схем /ЕБС/**

/9ш камер/




2020.03.20





Камерын байршил

**1-р давхарт камер суурилуулах схем /ЕБС/**

/9ш камер/




2020.03.20






Камерын байршил

## 2-р давхарт камер суурилуулах схем /ЕБС/

/9ш камер/




2020.03.20




 Камерын байршил

**3-р давхарт камер суурилуулах схем /ЕБС/**

**/9ш камер/**




2020.03.20




Камерын байршил

## Техникийн тодорхойлолт

| № | Төхөөрөмжийн нэр, төрөл, техникийн тодорхойлолт | Дүйцэхүйц зураг | Хэмжих нэгж | Тоо ширхэг |
|---|---|---|---|---|
| 1 | NVR 32 сувагтай бичигч ONVIF H+265, 768 mbps, 2 HHD slot, VGA, HDMI, USB |  | ш | 1 |
| 2 | Гадна зориулалтын чиглэлийн камер 2 MP, lens 4.0 mm, IP67, H+265 |  | ш | 8 |
| 3 | Дотор зориулалтын чиглэлийн камер 2 MP, lens 2.8-4.0 mm, IP67, H+265 камер |  | ш | 24 |
| 4 | HDD Хард диск Seagate 4TB Internal Hard Drive HDD – 3.5 Inch SATA 6 Gb/s 5400 RPM 256MB |  | ш | 2 |
| 5 | Повер толгой |  | ш | 32 |
| 6 | 220вт-12вт бууруулагч тэжээлийн блок 3А |  | ш | 20 |
| 7 | Коннектор оролт UTP |  | ш | 57 |
| 8 | TV 42 inch |  | ш | 1 |
| 9 | VGA ,HDMI залгуур /дүрсний/ 10 м |  | ш | 1 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 10 | Камерны суурь |  | ш | 8 |
| 11 | Сүлжээний утас дотор UTP кабель CAT 6 |  | м | 900 |
| 12 | Хос кабель |  | м | 300 |
| 13 | Тэжээлийн кабель утас |  | м | 50 |
| 14 | Утас дарагч лотки | | ш | 200 |
| 15 | Тэлэгч шруп |  | ш | 998 |
| 16 | Свич 5 порт 10/100 Mbps |  | ш | 10 |
| 17 | Свич 8 порт 100/1000 Mbps | | ш | 6 |
| 18 | Утас далдлагч /хамгаалагч хоолой/ |  | м | 110 |
| 19 | Тэжээлийн хайрцаг |  | ш | 10 |
| 20 | Дэлгэц тогтоогч 42' |  | ш | 1 |
| 21 | Тэжээлийн блок Тогтмол гүйдлийн тэжээлийн үүсгүүр 220v (12v 20A) |  | ш | 10 |

**БАЯН-УУЛ СУМЫН ЕБС**